

► Хүнд машин механизмын засварчин

Улаанбаатар хот
Ажлын байрны код: TM0119

Хойд Америкт төдийгүй олон улс дахь Комацу-гийн томоохон борлуулагч компаниудын нэг СМС Экьюпмент корпорацийн салбар компани болох Трансвест Монголиа ХХК нь үйлчлүүлэгчдийнхээ онцлогт тусгайлан тохируулсан содон шийдлүүдийг гаргаж өгдөг уул уурхайн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, тоног төхөөрөмж нийлүүлдэг тэргүүлэгч компани юм.

Бид Засвар үйлчилгээний газарт ажиллах Хүнд машин механизмын засварчин шалгаруулж авна.

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

Уурхайн тоног төхөөрөмжийн засварын мастерийн удирдлаганд дараах үндсэн үүрэгтэй ажиллана. Үүнд:

- Аюулгүй ажиллагааны арга барилыг мөрдлөг болгон манлайлж ажиллах;
- Компанийн төлөөлөл болохын хувьд хариуцлагатай байх;
- Өдөр тутмын засвар, үйлчилгээ, даалгасан үүрэг даалгаварыг үйлдвэрлэгчээс гаргасан стандарт, журмын дагуу цаг хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгэх;
- Ажлын чанарт хяналт тавих;
- Үйлчлүүлэгчид төвлөрсөн зарчим болон харилцан уялдааг дэмжиж ажилладаг байх;
- Ажлын ирц, оролцоог дээд зэргээр хангах;
- Гар багажуудыг байнга зөв, зохистой хэрэглэх;
- Засварын цехийн мастерын даалгасан бусад ажил үүргийг гүйцэтгэх зэрэг болно.

Тавигдах шаардлага:

- Мэргэжлийн үнэмлэхтэй байх;
- Хүнд машин механизмын засвар үйлчилгээгээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- Цаг баримталдаг, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нягт биелүүлдэг байх;
- Хөдөө орон нутаг, уурхайн талбарт томилогдон ажиллах боломжтой;
- Уурхайн тоног төхөөрөмжийн галын системтэй харицаж ажиллаж байсан туршлагатай;
- Цахилгаанчнаар ажиллаж байсан туршлагатай бол давуу тал;
- Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Сонирхсон хүмүүс ажилд орох хүсэлтээ хувийн намтрын хамт **2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17:00 цагаас өмнө careers@transwest.mn** хаягаар илгээнэ үү.

Трансвест Монголиа ХХК нь хүсэлт гаргасан та бүхэнд талархал илэрхийлэхийн зэрэгцээ зөвхөн сонгогдсон хүмүүсийг дараагийн шатны шалгаруулалтад оролцуулахыг мэдэгдэж байна.

Трансвест Монголиа ХХК тамхигүй орчныг дэмждэг.

